

мест, по мере возникновения дел и состоят из представителей Российского консула и князя того хошуна, к которому принадлежит или в котором проживает ответчик. Смешанным комиссиям представляется привлекать в качестве экспертов сведущих лиц из русских подданных, монголов и китайцев. Решения смешанных судебных комиссий приводятся в исполнение без замедления в отношении русских подданных через Российского консула и в отношении монголов и китайцев через князя того хошуна, к которому принадлежит или в котором проживает ответчик.

#### Статья 17.

Настоящий Протокол входит в силу со дня его подписания.

В удостоверение вышеизложенного обоюдные уполномоченные, найдя при сопоставлении обоих параллельных текстов настоящего Протокола — русского и монгольского, — изготовленного в двух экземплярах, эти тексты согласными, подписались на каждом из них, приложили печати и такими текстами обменялись.

Учинено в Урге, Октября 21 дня 1912 года, а по монгольскому летоисчислению во второй год правления «Всеми Возведенного» последнего осеннего месяца 24 дня.

(Подписи на монгольском языке).

Председатель Монгольского Совета Министров *Сайн Ноин хан*.

Полномочный Министр Внутренних Дел *Чин сузукту Цин-ван Лама*.

*И. Коростовец*.

Полномочный Министр Иностранных Дел в звании хана *Эрдени дайчин Цин-ван*.

Полномочный Военный Министр *Эрдени Далай дзюн-ван*.

Полномочный Министр Финансов *Тушету дзюн-ван*.

Полномочный Министр юстиции *Эрдени дзюн-ван*.

*Полное собрание законов Российской империи (3-е изд.). Петроград. 1915. № 38230. С. 1492–1495; АВПРИ, ф. 163, оп. 3, д. 963; ГАРФ, ф. Р-5804, оп. 2, д. 35, л. 1–2; Батсайхан О. Последний великий хан Монголии Богдо Джебцзундамба-хутухта VIII. Жизнь и легенды. М.: Товарищество научных изданий КМК, 2018 (факсимиле Соглашения на цветной вклейке).*

[Монгольский текст Русско-Монгольского соглашения и протокола 1912 г.  
на монгольской кириллице]

Монгол улсын нийт бүхнээр эртнээс тогтсоор ирсэн өөрийнхүү орны суртаал ба ёс журмыг алдагдахгүй сахихыг хүсэж Хятадын цэрэг ба эрх баригчдыг Монгол газраас үлдэн гаргаад, Жавзандамба хутагтыг Монгол Улсын хаан эзэнд өргөмжилсөн тул Монгол Хятад хоёрын хоорондох урьдын холбоо нь нэгэнт тасарсан ба одоо Орос, Монгол хоёр улс эртнээс нааш харилцан найрамдалтай учир Орос Монгол хоёрын худалдааг харилцан нэвтрүүлэх журмыг тодорхойгоор илтгэх нь чухал тул Монгол Улсын хаан эзний зарлигаар ба Монгол улсын засгийн газар ноёд сайдын газраас гаргасан бүрэн эрх барих сайд шадар сайд, Дотоод зэрэг олон яамны хамаг хэргийг бүгд ерөнхийлэн захирах сайд, Түмэнхэн номун эзэн Сайн ноён хан Намнансүрэн, Шадар сайд, Бүгд захирах сайд, Дотоод хэргийг бүгд захиран шийтгэгч яамны тэргүүн сайд чин сүжигт чин ван лам Цэрэнчимэд, Шадар сайд бүгд захирагч сайд, Гадаадын хэргийг бүгд эрхлэн шийтгэгч яамны тэргүүн сайд ханы зэрэг эрдэнэ дайчин чин ван Ханддорж, Шадар сайд, бүгд захирах сайд, Цэргийн хэргийг бүгд захиран шийтгэгч яамны тэргүүн сайд эрдэнэ далайжун ван Гомбосүрэн, Шадар сайд бүгд захирах сайд, Сангийн

хамаг хэргийг бүгд захиран шийтгэгч яамны тэргүүн сайд түшээтжун ван Чагдаржав, Шадар сайд бүгд захирах сайд, Шүүх таслах хэргийг бүгд захиран шийтгэгч яамны тэргүүн сайд эрдэнэжун ван Намсрай, Их Орос улсын хаан эзний засгийн газраас гаргасан бүрэн эрх барих сайд, действительный статский советник Иван Коростовец нар хэлэлцэн тогтоосон нь:

Нэгдүгээр зүйл. Их Орос улсын хаан эзний засгийн газраас Монгол улсыг туслахад өөртөө тогтнож өөрөө эзэрхэх ёс журам, өөрийн газарт хятадын цэрэг ба нүүдлийн иргэдийг оруулахгүй, өөрийн улсын цэрэг байгуулах эрхийг алдагдахгүй сахихад цөм тусалмуу.

Хоёрдугаар зүйл. Монгол улсын хаан эзэн ба Монгол улсын засгийн газраас өөрийн харьяат газарт Оросын албат нар ба оросын худалдааны эл онц эрхийг одоогийн хавсарган тогтоосон тусгай зүйлийг журамлан хуучин ёсоор хэрэгжүүлнэ. Монгол улсын газраа бусад гадаад олон улсын хүн нарт Оросын албат нарт олгосноос үлэмж эрх өгч үл болно.

Гуравдугаар зүйл. Монгол улс хэрэв Дундад улс ба жич олон гадаад улстай өөр гэрээ бичиг тогтоох нь болбоос энэхүү найрамдлын гэрээ бичиг ба хавсарган тогтоосон тусгай гэрээ бичигт заасан зүйлүүдийг Орос улстай урьдаар зөвлөлдсөн нь бус болбоос хэрхэвчээр халж эвдэж үл болно.

Дөрөвдүгээр зүйл. Энэхүү найрамдлын гэрээ бичгийг гарын тэмдэг тавьсан өдрөөс эхлэн ёсоор явуулна.

Дээр бичсэн найрамдлын гэрээ бичгийг хоёр этгээдийн тусгай бүрэн эрх баригчид монгол, орос үсгээр хошоод хувь бичээд харилцан нийлүүлж үзвээс утга нь нийлэлцсэн тул тус бүрт гарын тэмдэг тавьж тамгуудаа дарж батлаад солилцсон байна.

Монгол Улсын Олноо өргөгдсөний хоёрдугаар он Намрын сүүл сарын хорин дөрөвний өдөр Орос улсын нэг мянга есөн зуун арван хоёрдугаар он октябрь сарын хорин нэгний өдөр Монгол улсын нийслэлсэн Их Хүрээний газар тогтов.

Хавсарган тогтоосон тусгай гэрээ бичиг

Монгол Улсын хаан эзний зарлигаар ба Монгол улсын засгийн газраас тусгайлан гаргасан бүрэн эрх барих сайд шадар сайд, Дотоод зэрэг олон яамны хамаг хэргийг бүгд ерөнхийлэн захирах сайд, Түмэнхэн номун эзэн Сайн ноён хан Намнансүрэн, Шадар сайд, Бүгд захирах сайд, Дотоод хэргийг бүгд захиран шийтгэгч яамны тэргүүн сайд чин сүжигт чин ван лам Цэрэнчимэд, Шадар сайд бүгд захирагч сайд, Гадаадын хэргийг бүгд эрхлэн шийтгэгч яамны тэргүүн сайд ханы зэрэг эрдэнэ дайчин чин ван Ханддорж, шадар сайд, бүгд захирах сайд, Цэргийн хэргийг бүгд захиран шийтгэгч яамны тэргүүн сайд эрдэнэ далайжун ван Гомбосүрэн, шадар сайд бүгд захирах сайд, Сангийн хамаг хэргийг бүгд захиран шийтгэгч яамны тэргүүн сайд түшээтжун ван Чагдаржав, шадар сайд бүгд захирах сайд, Шүүх таслах хэргийг бүгд захиран шийтгэгч яамны тэргүүн сайд эрдэнэжун ван Намсрай.

Их Орос улсын хаан эзний засгийн газраас гаргасан бүрэн эрх барих сайд, действительный статский советник Иван Коростовец нар энэ өдөр тогтоосон найрамдлын гэрээ бичгийн хоёрдугаар зүйлийн ёсоор мөнхүү хоёр этгээдийн тусгай эрх баригчид зөвлөн хэлэлцэж, Их Орос улсын харьяат хүн нар Монгол улсын харьяат олон газар хэдийнээс хэрэглэсээр ирсэн ба нэмж олгох бас Монгол улсын хүнд Орос улсын харьяат олон газар олгох эл онц эрхийг тогтоож жагсаан бичсэн нь:

Нэгдүгээр зүйл. Их Орос улсын харьяат хүн нар Монгол улсын харьяат олон газар суух явах ба элдэв зүйлийн худалдаа нэвтрүүлэх, эд боловсруулах ба бусад аж үйлдвэр хийх, бас ч албан ба өөрийнхүү Орос, Монгол, Хятад гадаад улсын ганц нэг хүнтэй буюу пүүс ба ердийн хэлтэс, хэнтэй ч ялгаваргүй элдэв зүйлийн хэрэг учрыг хэлэлцэх эрхийг хуучин ёсоор хэрэглэнэ.

Хоёрдугаар зүйл. Их Орос улсын харьяат хүн нар хуучин ёсоор Орос, Монгол, Хятад ба жич бусад гадаад улсын аливаа газраас гарах ба боловсруулан үйлдсэн элдэв зүйлийн эд таваар оруулах ба гаргах бас эд таваарыг цаазлагдахгүйгээр худалдах эрх буй бөгөөд цөм гааль түрээс ба өөр алба

татвар өгөхгүй, хэрэв Орос, Хятад хоёр хоршоо нийлсэн ба бусдын эд таваарыг оросын хүн төлөөнөө хуурмагаар эзэрхвээс энэхүү зүйлд тогтоосон эрхийг олгохгүй.

Гуравдугаар зүйл. Их Орос улсын мөнгөний ердийн хэлтэс Монгол улсын харьяат олон газар өөрийн салбар хэлтэс байгуулж, мөнгөн ба бусад зүйлийн элдэв гүйлгээг гагц нэгэн хүнтэй буюу ердийн хэлтэс ба хоршоо нар лугаа хийх эрх буй.

Дөрөвдүгээр зүйл. Их Орос улсын харьяат хүн нар Монгол улсын харьяат олон газар худалдаж авах ба худалдахад бэлэн мөнгөөр буюу мал эд таваараар харилцан арилжаалж болох ба бас орос монгол харилцан эзэлдэж болно. Гагцхүү хувийн өрийг Монгол улсын сан ба хошуу төлөөнөө төлөхгүй.

Тавдугаар зүйл. Монгол улсын харьяат олон газар орны эрхийг баригчид монгол хятад хүн нар орос хүн лүгээ элдэв зүйлийн худалдааны хэрэг хийхэд ба бас тэд нарт буюу тэдний байгуулсан худалдаа ба эд боловсруулах аж үйлдвэрийн зэрэг газраа хүчин үнэлэгдэх хүнийг цаазалж үл болно. Албаны ба өөрийнхөө хоршоо буюу ердийн хэлтэс ба хүн нарт Монгол улсын харьяат олон газраас худалдаа ба эд боловсруулах зэргийн эрхийг ганцаарт бүрэн эзэрхүүлж үл болно. Энэ гэрээ бичиг байгуулахаас урьд хэрэв хоршоо буюу хүнд энэ мэт эрхийг ганцаарт бүрэн эзэрхүүлсэн нь буй аваас хугацаа дуусахын наана хуучин хэвээр явуулна.

Зургадугаар зүйл. Их Орос улсын харьяат хүн нар Монгол улсын харьяат олон газрын хот ба хошууны нутаг хаана ч болов худалдааны ба эд боловсруулах үйлдвэрийн хороо байшин ба пүүс, юм хадгалах орон байгуулах газрыг хугацаагаар хөлслөн авах буюу хувийн хөрөнгө болгон авах ба бас олон хошууны сул газрыг хөлслөн авч тариа хагалах эрх буй. Гагцхүү ашиг олохын тул дам худалдаж үл болно. Эдгээр газрыг Монгол улсын засгийн яам лугаа зөвлөн хэлэлцэж, эрхэм сүлд, малын бэлчээрт харшлахгүй болбоос хэмжээлэн зааж, Монгол улсын дүрмийн ёсоор өгнө.

Долдугаар зүйл. Их Орос улсын харьяат хүн нар Монгол улсын засгийн яам лугаа уул ойн баялаг хөрөнгө ба загас гөрөөлөх зэргийн ашиг авах хэргийг зөвлөн тогтоож болно.

Наймдугаар зүйл. Их Орос улсын засгийн газраас Монгол улсын харьяат аль нэгэн газрыг чухал болговоос Монголын засгийн яам лугаа зөвлөн хэлэлцэж консул байгуулах эрх буй. Бас Монгол улсын засгийн яамнаас Орос улсын аль нэгэн газрыг чухал болговоос Орос улсын засгийн газар лугаа зөвлөн хэлэлцэж хилийн ойрхи мужид төлөөний хүн байгуулж болно.

Есдүгээр зүйл. Их Орос улсын консул бүхий газар ба бас оросын худалдаанд чухал газар, оросын харьяат хүн нар суух ба элдэв зүйлийн аж үйлдвэр хийхэд хэрэглэх газрыг Орос улсын консул сайд, Монгол улсын засгийн яам лугаа харилцан хэлэлцэж тусгай газар хэмжээлж өгнө. Эдгээр газрууд нь мөнхүү консулын захиргаанд буй. Консулгүй газар бөгөөс оросын худалдааны даргын захиргаанд буй.

Аравдугаар зүйл. Их Орос улсын харьяат хүн нар Монгол улсын харьяат олон газрын хооронд ба эдгээр газраас Оросын зах хил хүртэл бичиг ба эд бараа зөөх учир хувийн хүчнээр өртөө байгуулах эрх буй тул Монгол улсын засгийн яам лугаа зөвлөн хэлэлцээд байгуулж болно. Энэхүү өртөөний гэр байшин зэргийг байгуулахад гэрээ бичгийн зургадугаар зүйлд заасан ёсоор шийтгэнэ.

Арваннэгдүгээр зүйл. Монгол улсын харьяат газар бүхий Их Орос улсын консул нар хэрэв албаны бичиг явуулах ба хүн зарах зэргийн албаны хэрэг буй аваас Монгол улсын албаны өртөөгөөр явуулна. Нэг сард нэг зуун морь, гучин тэмээнээс илүү улаа хэрэглэхгүй болгоно. Тухай бүр Монгол улсын засгийн яамнаас тэмдэг бичиг авна. Бас Оросын консулын зэрэг албаны түшмэд нааш цааш явахад мөн өртөөг хөлсөөр хэрэглэнэ. Бас Монгол улсын албаны өртөөгөөр явах эрхийг Орос улсын энгийн хүн нарт хүртээж болно. Гагцхүү энгийн хүн өртөөгөөр явах хөлсийг Монгол Улсын засгийн яам лугаа хэлэлцэн тогтооно.

Арванхоёрдугаар зүйл. Их Орос улсын харьяат хүн нарт Монголын харьяат газраас Оросын харьяат газар урсч орсон мөрөн гол ба түүний салбараар хувийн худалдааны онгоцыг хэрэглэн явж,

хөвөөнд орчим бүхий хүн нар лугаа худалдаа хийх эрх өгнө. Их Орос улсын засгийн хэрэг шийтгэх газраас Монгол улсын засгийн газарт эдгээр мөрөн голоор онгоц явуулах зам засах ба тэмдэг босгох зэрэгт тус хийнэ. Монгол улсын засгийн яамнаас эдгээр мөрөн голд онгоц татаж гаргах ба онгоцны өртөө байгуулах, юм зүйл хадгалах орон байгуулах, түлээ бэлтгэх зэрэгт газар хэмжээлж өгнө. Үүнд: энэхүү гэрээ бичгийн зургадугаар зүйлд заасан ёсоор шийтгэнэ.

Арвангуравдугаар зүйл. Эд бараа зөөх ба мал туухад Их Орос улсын харьяат хүн нар хуурай ба усан аль ч замаар явах эрх буй. Бас Монгол улсын эрх баригчидтай зөвлөн хэлэлцэж хувийн хүчээр гүүр ба ус гатлах арга зэргийг байгуулж, түүгээр явсан хүн нараас тусгай татвар авч болно.

Арвандөрөвдүгээр зүйл. Их Орос улсын харьяат хүн нар туусан малыг замын гудас зогсоож амруулах ба идэшлүүлж болно. Хэрэв удаан амруулах бол Монгол улсын харьяат газрын эрх баригчид мал туух замын гудас ба мал худалдах чухал газар бэлчээрийн газрыг хүрэлцэхээр хэмжээлэн өгнө. Гурван сараас илүү байваас хөлс авна.

Арвантавдугаар зүйл. Зах хилийн газар бүхий Их Орос улсын харьяат хүн нар Монгол улсын зах дотор ойр газар өвс хадах ба бас гөрөөчлөх, загас агнах тогтсон заншлыг үүнээс хойш өчүүхэн ч халж үл болно.

Арванзургадугаар зүйл. Их Орос улсын харьяат хүн нар ба ердийн хэлтэс монгол, хятад хүн нар лугаа худалдаа арилжааны хэрэг харилцан хэлэлцэхэд ам ба бичгээр хэлэлцэн тогтоож болно. Тэрхүү хоёр этгээд хэлэлцсэн гэрээ бичгээ Монголын нутгийн харьяат эрх баригчид мэдүүлэн гэрчлүүлбээс зохино. Хэрэв харьяат эрх баригчид гэрчилж үл болох учир буй аваас даруй Оросын консулд сонсож зөвлөн шийтгэнэ. Үүнд тогтоох нь: Хөдлөхгүй хөрөнгө авахад бичгээр тогтоод, Монгол улсын засгийн яаманд батлуулна. Ам ба бичгээр хэлэлцсэн хэргийн учир тэмцэл гарваас хоёр этгээд хүн сонгон гаргаж эв найрамдлын ёсоор хэлэлцэж хэргийг барагдуулна. Хэрэв энэ ёсоор найралдахгүй болбоос хоёр этгээд тусгай нийлэн шүүх газар шийтгэнэ. Нийлэн шүүх газар бөгөөс үргэлжийн ба цаг зуурын хэмээх хоёр зүйл буй амуй. Үргэлжийн нийлэн шүүх газрыг Оросын консул бүхий газар байгуулна. Энэхүү газар нийлэн шүүх түшмэд нь консул ба өөрөө буюу эсвэл өөр түшмэд төлөөнөө суулгана. Монгол улсын эрх баригчдаас тэнцэх зэрэг бүхий түшмэдийг төлөөнөө суулгана. Цаг зуурын нийлэн шүүх газрыг бусад газар хэргийн байдлыг үзэж түр байгуулна. Тэрхүү газар нийлэн шүүх түшмэд нь Оросын консулын төлөөний хүн нар ба тэмцлийн хүний харьяат буюу нутгийн харьяат хошууны ноёд ба ноёдын төлөөний хүн сууна. Тэр нийлэн шүүх газар хэрэг учир нэвтэрхий мэдэх хүнийг орос, монгол хэнийг ч болов ирүүлж болно. Нийлэн шүүх газар нэгэнт таслан шийтгэсэн хэргийг Орос улсын харьяат хүн болбоос Орос улсын консулаар уламжлуулан саатуулахгүй ёсоор болгоно. Монгол болбоос тэмцлийн хүний харьяат буюу нутгийн харьяат ноёдоор уламжлуулан саатуулахгүй ёсоор болгоно.

Арвандолдугаар зүйл. Энэхүү хавсарган тогтоосон тусгай гэрээ бичгийг гарын тэмдэг тавьж тамга дарж баталсан өдрөөс эхлэн журамлан дагаж явуулна. Энээг хавсарган тогтоосон тусгай гэрээ бичгийг хоёр этгээдийн тусгай бүрэн эрх баригчид монгол, орос хоёр зүйлийн үсгээр хавсарч хошоод хувь бичээд харилцан нийлүүлж үзвээс утга нь нийлэлцсэн тул тус бүрд цөм гарын тэмдэг тавьж тамга дарж батлаад харилцан солилцов.

Монгол улсын Олноо өргөгдсөний хоёрдугаар он Намрын сүүл сарын хорин дөрвөний өдөр  
Орос улсын нэг мянга есөн зуун арван хоёрдугаар он Октябрь сарын хорин нэгний өдөр  
Монгол улсын нийслэлсэн Их Хүрээний газар тогтоов.

*Батсайхан О. Последний великий хан Монголии Богдо Джебцундамба-хутухта VIII. Жизнь и легенды. М.: Товарищество научных изданий КМК, 2018. С. 374–375.*